

ХҮНИЙ БИЕ ЭРХТНИЙ НЭР ОРСОН ЯПОН, МОНГОЛ ӨВӨРМӨЦ ХЭЛЦИЙГ ХАРЬЦУУЛАХ НЬ

Б. Боргилмаа *

Манай улсад хэл шинжлэл, тэр дундаа орчуулга судлалын салбар далайцтай хөгжиж байгаа билээ. Цаашдаа орчуулгын ерөнхий онол судлал, шүүмжлэлийн зэрэгцээ тухайлсан тодорхой хоёр болон хэд хэдэн хэлний хооронд орчуулга хийх онол, практикийн асуудлыг шинжлэн судлах нь чухал ач холбогдолтой болж байна. Үүний зэрэгцээ нийгэм эдийн засгийн хөгжлийн хурдацтай хөл нийлж алхах зайлшгүй хэрэгцээнээс үүдэн мэргэжилтэй боловсон хүчин ч гадаад хэлийг сурч эзэмших, хэлний боловсролоо цаашид дээшлүүлэх сонирхол зүй ёсоор урган гарч ирсэн мэт санагдана.

Сүүлийн жилүүдэд Монгол, Япон хоёр орны найрсаг харилцаа өдрөөс өдөрт эрчимтэй өргөжин хөгжихийн хэрээр япон хэлийг сурах, сургах талаар багагүй бүтээл туурвил гарч, олны хүртээл болж байна. Монгол, япон хоёр хэлний харьцуулсан судалгаа хүрээгээ тэлж эрдэмтэн мэргэд төдийгүй залуу үеийхэн ч энэ талаар их зүйл бүтээж байгаа билээ. Гэвч япон, монгол хэлний өвөрмөц хэлцийг харьцуулан судалсан судалгаа харьцангуй хомс байгаа тул үгийн сангийн нэгэн чухал хэсэг болох япон хэлний өвөрмөц хэлцийг бүхэлд нь биш, зөвхөн хүний биеийн нэр орсон өвөрмөц хэлцийг монгол хэлнийхээ ийм өвөрмөц хэлцтэй харьцуулаад, утгын болон орчуулгын онцлог ялгаатай тал болон ижил төстэй талуудыг нь илрүүлэхийг чармайлаа. Өвөрмөц хэлцийг ингэж харьцуулан судлах нь зөвхөн хэл шинжлэлийн төдийгүй орон судлал, практикийн ач холбогдолтой далайд дусал нэмэрлэхээр гэж үзэж байна.

Эрхэлдэг аж ахуй, ертөнцийг үзэх үзэл, сүсэг бишрэл сэтгэхүйн хувьд өөр өөр ард түмний үндэсний хэлэнд бие эрхтэнтэй холбоотой үүссэн өвөрмөц хэлц бусад хэлцээсээ харьцангуй их байгаа нь аливаа бодит зүйлсийн бүрэлдэхүүнийг өөрийн эд эрхтэний бүтэц байртай дүйцүүлэн ойлгодог сэтгэхүйн онцлог хүн төрөлхтөнд ижил байгаагийн илрэл юм.

Эрдэмтэн Г. Акимын “Монгол хэлний өвөрмөц хэлцийн товч тайлбар толь”-д байгаа нийт 1000 орчим хэлцийн ойролцоогоор 25% буюу 250-аад, “Япон хэлний өргөн хэрэглээний өвөрмөц хэлцийн толь”-д байгаа нийт 4500 орчим өвөрмөц хэлцийн 24% буюу 1100 нь хүний амьдралын өдөр тутмын үйлдэл эд эрхтэнээр дамжин илэрч, гүйцэлддэгтэй холбоотойгоор бие эрхтэний өвөрмөц хэлц үүсдэгийг баталж байна. Эдгээр хүний биеийн эд эрхтэнтэй холбоотой үүссэн өвөрмөц хэлцээс “ам” гэсэн үг оролцсон өвөрмөц хэллэг хамгийн их буюу нийт үгийн 11%-ийг эзэлж байгаа нь хүн юм үзэгдэл, орчин

* МУИС, ОУХС-ийн багш, магистр

тойрноо танин мэдэж, түүнийгээ өгүүлэх эрхтэнээрээ илэрхийлдэгтэй холбоотой гэж үзэж байна.

Япон хэлний өвөрмөц хэлцийн утгыг монгол хэлнийхтэй харьцуулахдаа өвөрмөц хэлцэд идэвхтэй эрхтэнүүд болон онцлог ялгаатай утга илэрхийлэхэд оролцож байгаа зарим эрхтэнүүдийг авч үзье. Хүний бие эрхтэний нэр орсон монгол, япон өвөрмөц хэлцийн утгыг харьцуулан авч үзэхэд монгол, япон хүмүүс сэтгэлгээний хувьд нэлээд ойр байна. Өвөрмөц хэлцэд хамгийн идэвхтэй байгаа ам, гар, толгой, хөл гэх мэтийн эрхтэний үүрэг, байрлалаар нь зүйрлэсэн утгууд ерөнхийдөө төстэй байна. Жишээ нь: “Ам”: орсон өвөрмөц хэлц нь хоёр хэлэнд ярих, идэх утга, мөн хүний зан чанарыг илэрхийлэх, хүний харьцаа, сайн муу үйлийг илэрхийлэхийнхээ хувьд адил юм. Жишээ нь 口が酸っぱくなる(kuchi ga suppakunaru)-ам хамхилгүй, 口に合う(kuchi ni au)-амт нь таалагдах, 口が軽い(kuchi ga karui)-ам задгай. Харин монгол хэлэнд бэлэгдэл болон ёрлолын утгатай өвөрмөц хэлц амны хишиг, алтан амтай гэх мэт хэд хэд байх атал япон хэлэнд алга.

“Гар”: Ажил, хөдөлмөр хийх, эрх мэдэл, өмчлөх харьяалах, харьцаа, тусалж дэмжих, хөрөнгө мөнгө, хүний зан чанарын зэрэг утга нь хоёр хэлэнд ижил байна. Жишээ нь: гар хумхилгүй, гартаа оруулах, гар сунгах, гарын салаагаар юм гарахгүй, 手を貸す(te wo kasu) -гар сунгах, 手に入る(te ni hairu) гарт орох, 腕を磨く(ude wo migaku) хийгээ арилгах, 手を握る(te wo nigiru)- гар гараа барилцах.

Харин монгол хэлэнд монгол зан үйл, ахуй амьдралын утгатай хэлц: гар зөрүүлэх- золгох, гар дээр өсөх гэх мэт байхад япон хэлэнд байхгүй.

“Нүд”: Үзэх, харах, үхэх, унтахын утга, хүний зан араншин, харьцаа, сэтгэлийн өнгө аяс, юмны өнгө үзэмж, шинж чанар, танин мэдэхүй, зайн хол ойр болон хугацааг илэрхийлэхдээ энэ эрхтэний нэрийг оруулсан нь ерөнхийдөө адил юм. Жишээ нь: нүд унагах, нүдний хор гарах, нүд аних, нүд өөхлөх, нүд үзүүрлэх, нүд алдам, нүд тайлах, нүд ирмэх зуур:, 目が黒いうち(me ga kuroi uchi) /нүд хар байхад/ хүзүү мөрөн дээр байх, 目が覚める(me ga sameru) /нүд сэрэх/-учрыг ухаарах. Мөн нүдний цөцгий мэт хайрладаг, өхөөрддөг гэдгийг 目に入れても痛くない(me ni iretemo itakunai) нүдэндээ хийхэд ч өвдөмгүй гэж илэрхийлдэг нь бас өвөрмөц боловч нүд, нүдний цөцгийг нандин эмзэг гэж үздэг монгол хүнд ойлгогдохгүй байж болох юм.

“Толгой”: Юмны эх болох, бодох сэтгэх гэсэн утга нь хоёр хэлэнд адил бууж байгаа бөгөөд цаашилбал эрх мэдэл, аж амьдрал зан үйл, хүний сэтгэл хөдлөлийн утгууд мөн хоёуланд нь илэрч байна. 頭にくる(atama ni kuru) /толгойд ирэх/-уурлах, цухалдах. Хүн аливаа юмыг үнэлэх үнэлэмжийн тухайд 頭が高(atama ga takai) толгой өндөр - дээгүүр зантай, 頭が低い(atama ga hikui) толгой намхан - юмыг доогуур үнэлдэг гэх зэргээр хэлсэн хэлц нь монгол хэлэнд байхгүй онцлогтой.

Тухайн эрхтэнээр илэрхийлэх утгын хувьд ялгаатай зүйл бас байна. Япон хэлэнд зоригийг элгээр, сэтгэлийг цээжээр, сэтгэлийн мэдрэмжийг гэдсээр, ам насыг хүзүүгээр илэрхийлдэг нь монгол хэлэнд зүрх, элэг, толгойгоор илэрхийлж байгаа утгууд юм. Мөн тухай тухайн тохиолдолд л ялгаатай утга илэрхийлэх нь байна.

Өвөрмөц хэлцийг нэг хэлнээс нөгөө хэл рүү хэрхэн орчуулах тухай манай эрдэмтэд цөөнгүй бичсэн байдаг. Өвөрмөц хэлцийг орчуулах нь хэл шинжлэлийн чухал асуудлын нэг бөгөөд онолын болоод хэрэглээний чухал ач

холбогдолтой. Эрдэмтэн Д. Дашдаваа “Орчуулгын тухай тэмдэглэл” номоо гадаад дотоодын олон эрдэмтэд хэлц үгийг орчуулах олон аргуудыг судалгааны үндсэн дээр тогтоон гаргасан гээд эл бүх арга зам нь нэр томъёогоороо ялгаатай авч агуулгынхаа хувьд өөр хоорондоо ойролцоо юм гэжээ.¹

Япон өвөрмөц хэлцийг монгол хэлнээ орчуулахдаа энэ номд түүний тодорхойлсон аргуудыг баримталвал:

1. Япон хэлний хэлц үгтэй илтгэх утга, гаргах дүр, найруулгынхаа өнгөөр бүрэн дүйж байгаа тэнцүү хэлцээр: 口が堅い (kuchi ga katai) - ам бөх, ам хатуу, 足が出つかない (ashi ga tsuchi ni tsukanai) -хөл газар хүрэхгүй, 気が合う (ki ga au) -санаа нийлэх, 頭がいい (atama ga ii) -толгой сайтай.

2. Илтгэх утга, найруулгын өнгөөрөө ижил боловч гаргах дүр нь өөр өвөрмөц хэлцүүдийг тэнцүү биш хэлцээр орчуулах. Жишээ нь: 目がない (me ga nai) /нүд үгүй/- нугасгүй, あごをなでる (ago wo naderu) /эрүүгээ илэх/- гэдсээ илэх, 揚げ足を取る (ageashi wo toru) /өргөсөн хөл авах/- ул шагайх, 手を貸す (te wo kasu) /гараа зээлүүлэх/- гар сунгах, 青筋を立てる (aosuji wo tateru) – гүрээнийхээ судсыг гүүн зэл шиг болгох, 耳に入る (mimi ni hairu) /чихэнд орох/- чих дэлсэх, 腹を立てる (hara wo tateru) /гэдэс босгох/- цөс цалгих.

3. Тэнцүү буюу тэнцүү биш чанартай, дүйх хэлц байхгүй тохиолдолд зарим хэлцийг үгчлэн (хуулбарлан) орчуулж болно. Хэлэхэд уран, уншихад эвтэй байвал хааяа хэрэглэж болох арга юм. 頭が痛い (atama ga itai) /толгой өвдөх/- шаналах, 足が鈍る (ashi ga niburu) /хөл мохох/- дургүйд хүчгүй, 目に立つ (me ni tatsu) /нүдэнд босох/-нүд шүд болох, あごではえを追う (ago de hae wo ou) /эрүүгээрээ ялаа үргээх/- хуруугаа ч хөдөлгөх тэнхэлгүй.

4. Хам сэдэвтэйгээ нягт уялдаатай хэлцийг өгөгдсөн дүйх хэллэгээр нь биш, тухайн хам сэдэвт таарах энгийн үг хэллэг, үг, өөр хэлцээр орчуулах тохиолдол бас гарна.

5. Дээр дурьдсан аргуудын алинаар нь ч орчуулж боломгүй тохиолдолд чөлөөт нийлэмжээр буюу энгийн үгээр тайлбарлан орчуулж болдог. 首を切る (kubi wo kiru)/хоолойг нь огтлох/-ажлаас гарах, 氣に入る (ki ni iru)/санаа сэтгэлд орох/-таалагдах, 身につく (mi ni tuku) /биед наалдах/-гарт орох, эзэмших, 肩で風を切る (kata de kaze wo kiru)/мөрөөр салхи зүсэх /- цээж тэнэгэр, маадгар. 手の内を見せる (te no uchi wo miseru)/гарын дотор үзүүлэх/- дотроо уудлах. Энэ аргын дутагдалтай тал нь сэтгэл хөдлөл, найруулгын өнгө нь алдагдаж, яруу бус болгожээ.

Өвөрмөц хэлцийн бүтцийн хувьд мөн хоёр хэлний өвөрмөц хэлц ижил төстэй байгаа боловч хэл зүйн хувирлын хувьд бага зэргийн ялгаатай тал ажиглагдаж байна. Хоёр хэлний өвөрмөц хэлц нь нэрийн бүлэг, үйлийн бүлгийн болон бие даасан өгүүлбэр хэлбэртэй байгаа нь адил. Мөн тийн ялгалын нөхцөлтэй, нөхцөлгүй хоёр хэлбэрээр хэлж байгаа нь адил. Монгол хэлэнд заахын тийн ялгал, япон хэлэнд нэрлэх, заахын тийн ялгалын нөхцөл хураагдах тохиолдол олон байна. Монгол хэлэнд хамаатуулахын-нь, -аа⁴ нөхцөлтэй, нөхцөлгүй хэрэглэдэг хэлцүүд байдаг нь онцлог юм.

Япон, монгол аль ч хэлэнд ганц үгнээс тогтсон өвөрмөц хэлц байгаа тул нэг үгээс бүтсэн өвөрмөц хэлц гэсэн зүйлийг монгол өвөрмөц хэлцийн ангилалд нэмж оруулах нь зүйтэй байна. Гарлаараа хэд хэдэн үг байж байгаад сүүлд нь нэг үгэндээ утга нь төвлөрсөн хэлцүүдийг үүнд хамруулж байгаа юм. Жишээ нь:

¹ Д. Дашдаваа. Орчуулгын тухай тэмдэглэл. 1974

хумслах, элэгтэй, нугасгүй, махрах, хөлжих, нүүргүй. Эдгээр үгс нь хэл зүйн утгаас гадна үгийн сангийн утгатай.

Ном зүй

1. Т. Аким. Монгол өвөрмөц хэлцийн товч тхйлбах толь. УБ., 1999
2. Д. Бадамдорж. Монгол хэлний утга судлал. 2-р боть. 2001
3. Д. Бадамдорж. Монгол хэлний утга судлал. 3-р боть. 2003
4. Д. Дашдаваа. Орчуулгын тухай тэмдэглэл. 1974
5. Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966
6. Япон хэлний өргөн хэрэглээний өвөрмөц хэлцийн толь.